

ШИЛЭН КАБЕЛИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2019 оны 09 дугаар
сарын 09-ны өдөр

Дугаар АГГ-19/192180/76

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг үндэслэн

Нэг талаас "Монголын төмөр зам" ТӨХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Цэнгэл (цаашид "Захиалагч" гэх);

Нөгөө талаас "Арбэл-Алтай" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ц.Нямсүрэн нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) энэхүү гэрээнд заасан нөхцөлөөр төмөр замын шилэн кабелийн зураг төсөл боловсруулах ажил гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулахаар харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг дахь "УБТЗ" ХНН-ийн Зүүнбаян өртөөнөөс Өмнөговь аймгийн Цогтцэцийн сумын нутагт орших Тавантолгой нүүрсний орд хүртэл 416 км төмөр замын ойролцоогоор 830 км /нөөц цагираг сүлжээтэй/ шилэн кабелийн зураг төслийг Гүйцэтгэгч боловсруулах ажил /цаашид "Ажил" гэх/-ыг гүйцэтгэх, Захиалагчид хүлээлгэн өгөх, Захиалагч нь тохиролцсон ажлын хөлсийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулж, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

1.2. Энэхүү гэрээ нь энэ гэрээ болон гэрээний хавсралтуудаас бүрдэнэ. Гэрээ, түүний хавсралт, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

1.3. Гүйцэтгэгч нь төмөр замын шилэн кабелийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, норм, дүрэм, стандартад нийцүүлэн ажлын даалгаврын дагуу энэхүү гэрээнд заасан хугацаанд багтаан боловсруулан батлуулж Захиалагчид хүлээлгэн өгнө.

1.4. Дараах бичиг баримтыг гэрээнд хавсаргах бөгөөд эдгээр нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:

- 1.4.1. Зураг төсөл боловсруулах ажлын график
- 1.4.2. Төсвийн зардлын задаргаа
- 1.4.3. Батлагдсан ажлын даалгавар

Хоёр. Баталгаа

2.1. Гүйцэтгэгч нь дараах баталгааг гаргаж байна. Үүнд:

2.1.1. Гэрээний дагуу ажил гүйцэтгэх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай Тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, тэдгээр нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчин, санхүүгийн бүрэн чадамжтай гэдгийг;

2.1.2. Гүйцэтгэгч нь ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт болон энэ гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн, эрхийн болон биет байдлын доголдолгуй, холбогдох бичиг баримтын хамт үнэн зөв, иж бүрдэл бүрэн, гүйцэд хүлээлгэж өгнө гэдгийг;

2.1.3. Талууд энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж мэдсэн нөгөө талын үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээллийг тухайн талын зөвшөөрөлгүйгээр Хууль болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй, энэхүү гэрээнээс үүссэн харилцаанаас өөр бусад зорилгоор ашиглахгүй байхыг.

Гурав. Хууль тогтоомж, гэрээг тайлбарлах

3.1. Талууд энэхүү гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэн, эрх бүхий байгууллагаас баталсан шилэн кабелийн зураг төсөл аливаа дүрэм, журам, заавар, стандарт, шаардлагад нийцүүлэн Талуудын хоорондын эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан байгуулав.

3.2. Гэрээний зүйл заалт, уг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд хэрэв энэ гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хуульд заасныг баримтална.

Дөрөв. Гэрээг байгуулсанд тооцох

4.1. Гэрээнд талуудын төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

4.2. Гэрээг Монгол хэлээр хоёр хувь үйлдэх ба Гүйцэтгэгч, Захиалагч тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд эдгээр хууль зүйн адил хүчинтэй байна.

Тав. Гүйцэтгэх ажил, ажлын гүйцэтгэл

5.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Дорнговь аймгийн Сайншанд сумын нутаг дахь “УБТЗ” ХНН-ийн Зүүнбаян өртөөнөөс Өмнөговь аймгийн Цогцэцийн сумын нутагт орших Тавантолгой нүүрсний орд хүртэл 416 км төмөр замын ойролцоогоор 830 км /нөөц цагираг сүлжээтэй/ шилэн кабелийн зураг төслийг Захиалагчийн өгсөн ажлын даалгавар болон гэрээнд заасан нөхцөлөөр, тогтоосон хугацаанд багтаан боловсруулж ажлын үр дүнт Захиалагчид хүлээлгэн өгнө.

5.2. Ажлын үр дүн нь холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, заавар, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байх бөгөөд Захиалагчийн өмч байна.

5.3. Гүйцэтгэгчийн талаас алдаатай зураг төсөл хийснээс болж ажлын явцад ямар нэгэн ажлыг нэмж хийх шаардлага гарвал Гүйцэтгэгч өөрийн зардал, хөрөнгөөр засч, учирсан хохирлыг барагдуулна.

5.4. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх хугацаанд ажил гүйцэтгэхэд шаардлагатай бичиг баримтууд болон Захиалагчид шаардлагатай мэдээллийг бүрэн гаргаж өгнө.

Зургаа. Ажил гүйцэтгэх хугацаа

6.1. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дууссан байх ба хуанлийн 30 хоногийн дотор Гүйцэтгэгч зураг төслийн ажлыг гүйцэтгэж, магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэхээр Барилгын хөгжлийн төвд хүлээлгэж өгсөн байна.

6.2. Гүйцэтгэгч нь гүйцэтгэсэн зураг төсөлд магадлалын ерөнхий дүгнэлт хийлгэж ажлыг аль болох богино хугацаанд хийгэхээр эрмэлзэж ажиллана.

6.3. Барилгын хөгжлийн төвөөр зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулсан, магадлагдсан зураг төслийг Захиалагчид энэхүү гэрээний 9-д заасны дагуу хүлээлгэн өгнө.

6.4. Захиалагчийн шаардсан тухай бүрт Гүйцэтгэгч нь хийгдэж буй ажлын талаар мэдээлэл, тайланг хүргүүлнэ.

6.5. Гүйцэтгэгчийн ажлын зохион байгуулалт, үйл ажиллагаа, шаардлагатай техник тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг зөрчих буюу хойшлуулах үндэслэл болохгүй.

6.6. Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь Гүйцэтгэгчид захиалагчийн зүгээс энэ гэрээнд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

Долоо. Ажлын доголдлыг арилгах, гомдлын шаардлага гаргах

7.1. Гүйцэтгэгч нь ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, эсхүл Захиалагч, төрийн эрх бүхий хяналтын байгууллагын бичгээр өгсөн чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон энэ гэрээний гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг өөрийн хөрөнгөөр засч, доголдлыг арилгах, үүнээс үүсэн Захиалагч, гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

7.2. Гүйцэтгэгч ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд Захиалагч, гуравдагч этгээдэд учирсан шууд болон шууд бус хохирлыг бүрэн хариуцна.

7.3. Гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш гурван жилийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

Найм.Мэдээлэл солилцох, мэдээллээр хангах

8.1. Талуудын албан ёсны хаяг:

8.1.1. Захиалагч: "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани
Улсын бүртгэлийн дугаар: 9012001025
Регистрийн дугаар: 5214203

Хаяг: Юнион бюлдинг, А блок, 7 давхар, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, 13 хороолол, Нарны зам-62, Улаанбаатар /14230/
Утас: 7000-6622, 7010-6655
Имэйл: info@mtz.mn

8.1.2. Гүйцэтгэгч: "Арбэл-Алтай" ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011106027
Регистрийн дугаар: 5143594

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: 3Т12-1721/17

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө,
4-р хороо, 15 хороолол, 40-6 тоот
Утас: 96114455, 99007596
Имэйл: Arbel_altai@yahoo.com

8.2. Гэрээний талууд үйл ажиллагаа эрхлэн явуулахад шаардлагатай мэдээллийг зөвхөн албан бичгээр харилцан солилцож байна.

8.2.1. Захиалагч талыг төлөөлж мэдээлэл солих ажилтан:

Холбооны инженер Г.Дөлгөөн барих ба холбоо барих утас: 95110025,
и-мэйл хаяг: dulguun@mtz.mn

8.2.2. Гүйцэтгэгч талыг төлөөлж мэдээлэл солих ажилтан:

Холбооны зөвлөх инженер Д.Доржсүрэн, холбоо барих утас 91199898
Холбооны зургийн инженер Д.Солонго, холбоо барих утас 96100440

и-мэйл хаяг: Arbel.altai.mn@gmail.com, arbel@arbelaltai.mn

8.3. Мэдээллийг бичгээр харилцахдаа факс, и-мэйл зэрэг цахим хэлбэрийг

ашиглана.

8.4. Хойшпуулашгүй тохиолдолд Талууд мэдээллээ амаар болон утсаар солилцож болох боловч ийнхүү солилцсон мэдээллээ баталгаажуулж 48 цагийн дотор нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

8.5. Мэдээлэл солилцоноос үүсэх хохирлыг захиалагч хариуцахгүй.

8.6. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ баримт, судалгаа, зааварчилгааг Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу боломжит хугацаанд гаргаж өгнө.

Ес. Ажил хүлээлцэх

9.1. Талууд ажлын гүйцэтгэлийг хүлээлцэхдээ тал тус бүрээс 2-оос доошгүй ажилтан оролцуулсан ажил хүлээлцэх комисс байгуулна.

9.2. Талууд гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийг хүлээлцсэнээс хойш 3 /гурав/ хоногийн дотор ажлын бичиг баримтыг акт үйлдэн хүлээлцэнэ.

9.3. Бичиг баримтыг хүлээлцэхдээ бичиг баримтын бүрдэл бүрэн гүйцэт, үнэн зөв эсэхийг шалган, Захиалагч бичиг баримтын эх хувийг хүлээн авна. Гүйцэтгэгч бичиг баримтын бүрдэл бүрэн гүйцэт, үнэн зөв эсэхийг хариуцан хүлээлгэн өгнө.

9.4. Гүйцэтгэгч өөрийн архивд авч үлдсэн хувиас шаардлагатай тохиолдолд Захиалагчийн хүсэлтийн дагуу үнэ телбөргүй хуулбарлан авах боломжоор хангаж хуулбарыг баталгаажуулна.

9.5. Ажил хүлээлцэж дууссаны дараа Захиалагч эрх бүхий байгууллагаар магадлан баталгаажуулсан Дорнговь аймгийн Сайншанд сумын нутаг дахь "УБТЗ" ХНН-ийн Зүүнбаян өртөөнөөс Өмнөговь аймгийн Цогцэцийн сумын нутагт орших Тавантолгой нүүрсний орд хүртэл төмөр замын шилэн кабелийн зураг төсөл, байрзүйн зураглалын тайлантай болсон байна.

9.6. Ажил хүлээлцсэнээр Ажлын үр дүн нь Захиалагчийн өмчлөлд шилжинэ.

9.7. Талууд ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээ, явц, чанар, байдлын талаар харилцан тохиролцож чадаагүй, эсхүл аль нэг талын гаргасан тайлбар, үндэслэл, дүгнэлтийг нөгөө тал хүлээн зөвшөөрөөгүй бол Захиалагчийн сонгосон шинжээчээр дүгнэлт гаргуулж, ажлын гүйцэтгэлийг хүлээн авна. Ийнхүү дүгнэлт гаргуулахад гарсан нэмэлт зардлыг ажил гүйцэтгэгч бүрэн хариуцна.

Арав. Ажлын хөлс, төлбөр тооцоо

10.1. Энэхүү гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх ажлын хөлс нь 380.000.000 /гурван зуун наян сая/ төгрөг байна. Энэхүү үнэ гэрээний хугацаанд тогтмол байна.

10.2. Захиалагч нь урьдчилгаа төлбөр болгож үнийн дүнгийн 30 хувь буюу 114.000.000 /нэг зуун арван дөрвөн сая/ төгрөгийг гэрээ хүчин төгөлдөр болж, урьдчилгаа төлбөрийн баталгааг банкнаас гаргуулж ирүүлснийг үндэслэн гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан шилжүүлнэ.

10.3. Дундын санхүүжилт болох 30 хувийг зураг төсөв бүрэн дуусаж холбогдох албан тушаалтанаас гарын үсэг, зөвшөөрөл авч барилга хөгжлийн төврүү магадлал хийх албан тоот өгсөнийг үндэслэн олгоно.

10.4. Сүүлийн санхүүжилт 35 хувийг зураг төсөл магадлал хийгдэн ажлыг хүлээлцсэн акт, гэрээний дүгнэлтийг үндэслэн ажлын 7 хоногт багтаан төлнө.

10.5. Ажлын хөлсийг Гүйцэтгэгчийн ХААН банкны 5020420583 тоот төгрөгийн данс руу шилжүүлнэ.

10.6. Ажлын хөлсөнд холбогдох зураг төсөл гүйцэтгэх болон магадлал ерөнхий дүгнэлт хийлгэх зардал, НЭАТ, холбогдох бүх төрлийн татвар, хураамж, үндсэн ажлын холбогдох зардлууд бүгд багтсан болно. Дээрх үнэнд зохиогчийн хяналтын зардал ороогүй болно.

10.7. Барилгын угсралтын ажлын явцад зохиогчийн хяналт хийх ажлын зардлыг БНБД 11-04-99-ийн дагуу тусгай гэрээгээр зохицуулна.

10.8. Ажлын хөлс нь өөрчлөгдхөгүй, тогтвортой ба ажил гүйцэтгэх хугацаанд шаардлагатай үндсэн бараа, материал, түлшний үнэ өссөн зэрэг Захиалагчаас үл

шалтгаалах байдлаар ажлын өртөг нэмэгдэхтэй холбогдсон эрсдэлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

10.9. Гэрээний үнийн 5 /тав/ хувийг гүйцэтгэлийн чанарын баталгаа болгон барьцаа хэлбэрээр батлагдсан зураг төслийг хүлээн авснаас хойш 6 сарын хугацаанд Захиалагчийн дансанд үлдээнэ.

Арван нэг. Захиалагчийн эрх, үүрэг

11.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;

11.2. Ажлын явцын тайланг Гүйцэтгэгчээс авах;

11.3. Гүйцэтгэгч талын үйл ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчлийн улмаас үүссэн аливаа хохирлыг нөхөн төлүүлэх, ажлын тайлан, дүгнэлтийн хувьд гарсан бүх алдаа, зөрчлийг үнэ төлбөргүй дахин боловсруулуулах, шинэчлүүлэх талаар шаардлага тавих;

11.4. Шаардлагатай тохиолдолд ажлын гүйцэтгэлд нарийн мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх;

11.5. Захиалагч нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг Гүйцэтгэгчид хугацаанд нь төлөх;

11.6. Гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд өөрсдийн зүгээс шаардлагатай туслалцааг Гүйцэтгэгч талд үзүүлэх;

11.7. Захиалагчийн зүгээс ажил хийж гүйцэтгэхтэй холбогдсон шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

11.8. Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Арван хоёр.Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

12.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Захиалагчаас шаардах;

12.2. Гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг хүлээн авах;

12.3. Захиалагч талаас гаргаж өгөх ажлын хүрээндэх мэдээ материалыг боломжит цаг хугацаанд нь шаардан авах;

12.4. Гэрээнд заасан ажлыг Харилцаа холбооны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм, Холбооны кабель шугамын ажлын зураг төсөв хийх стандарт MNS 6305:2012, Шилэн кабелийн угсралт, сууринуулалтын стандарт MNS 5278:2012, Холбооны кабелийн сууринуулалт, ерөнхий шаардлага MNS 5276:2003, Цахилгаан холбооны сүлжээний байгууламжид тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага MNS 5596:2006, Техникийн зурагт телефон сүлжээний тэмдэглэгээ, тэмдэглээний хэмжээ MNS 4908:2000, Барилгын зурагт мэдээлэл, холбоо, дохиоллын тоног төхөөрөмжийн тэмдэглэгээ MNS 5532:2016, Барилгын зураг. Барилга байгууламжийн мэдээлэл, холбоо, дохиоллын ажлын зураг төсөл боловсруулах ерөнхий шаардлага MNS 6586:2016 стандарт болон бусад холбогдох дүрэм журам, стандарт, аргачлал, Захиалагчаас өгсөн ажлын даалгаврын дагуу гүйцэтгэн, зураг төслийн баримт бичиг З хувь болон файл хэлбэрээр зураг төслийг хүлээлгэн өгөх;

12.5. Ажлын үр дүн, тайлан дүгнэлтэд тусгагдсан норматив болон тооцооны үзүүлэлтүүдийн үнэн зөвийг бүрэн хариуцах;

12.6. Гэрээт ажил, тайлан дүгнэлтэй холбогдсон алдаа, зөрчил, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгдээгүй ажил бий болсон тохиолдолд Захиалагчид дахин үнэ төлбөргүйгээр засч өгөх, хохирлыг барагдуулах;

12.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг хариуцах үүрэгтэй.

12.8. Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Арван гурав. Нууцлал

13.1. Хууль болон гэрээнд зааснаас бусад тохиолдолд нөгөө Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээний талаарх аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

Арван дөрөв. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

- 14.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 14.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө Талдаа саналаа бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, түүний төслийг тусгана.
- 14.3. Саналыг хулээн авсан тал ажлын 1 хоногийн дотор хариу ирүүлэх үүрэгтэй бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.
- 14.4. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

Арван тав. Гэрээний зөрчлийг арилгах, гэрээ цуцлах

- 15.1. Талууд гэрээний үүргийн зөрчлийг арилгах тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан тал гэрээний зөрчлийг ажлын 5 хоногийн дотор арилгаж хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.
- 15.2. Хэрэв зөрчил гаргагч Тал зөрчлийг ажлын 5 хоногийн дотор арилгах боломжгүй бол энэ тухай нөгөө Талдаа мэдэгдэх бөгөөд зөрчил арилгах хугацааг Талууд харилцан тохиролцож тогтооно.
- 15.3. Талууд гэрээг цуцлах саналтай байгаа бол уг саналаа нөгөө Талд бичгээр хүргүүлж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 15.4. Захиалагч нь дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:
 - 15.4.1. Гүйцэтгэгч энэ гэрээний дагуу ажил гүйцэтгэх хугацааг 10 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн;
 - 15.4.2. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхдээ чанарын ноцтой доголдол гаргасан бөгөөд захиалагч ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн;
 - 15.4.3. Гүйцэтгэгч нь ажлын доголдлыг боломжит хугацаанд арилгаагүй, эсхүл ийнхүү арилгахаас зайлсхийсэн;
 - 15.4.4. Гүйцэтгэгчийн баталгаа нь хуурамч болох нь илэрсэн;
 - 15.4.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

- 15.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

- 15.5.1. Захиалагч төлбөрөө шилжүүлэх хугацааг 10 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн, цаашид боломжит хугацаанд шилжүүлэхгүй нь тодорхой болсон;
- 15.5.2. Захиалагч ажлын хамрах хүрээг өөрчилсөн нь энэхүү гэрээнд заасан ажлын хөлсийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгосон бөгөөд захиалагч нэмэлт санхүүжилтийг гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан;
- 15.5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

- 15.6. Гэрээг цуцалсан тохиолдолд ийнхүү цуцалснаас хойш ажлын 3 хоногийн дотор гэрээ цуцалсан өдрөөр тасалбар болгон Захиалагч гуравдагч ажил гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлэх эрхтэй. Хэрэв гүйцэтгэгчийн зохих ёсоор гүйцэтгээгүй ажлыг гуравдагч ажил гүйцэтгэгч үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой тохиолдолд тухайн ажилд ногдох гүйцэтгэгчийн зардлыг захиалагч төлөх тохиолдолд гуравдагч ажил гүйцэтгэгчтэй зөвшилцсөнийг үндэслэн тооцно.

Арван зургаа. Хариуцлага

- 16.1. Гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.
- 16.2. Энэ гэрээний 15.4-д заасны дагуу гэрээг захиалагчийн санаачлагаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний торгууль

хүлээх бөгөөд захиалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.

16.3. Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.

16.4. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нэгээ талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнэ.

16.5. Хэрэв аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд нэгээ тал нь шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол энэ нь эрхээсээ татгалзсан гэж тооцохгүй бөгөөд эрхээ хожим хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахад саад болохгүй.

16.6. Аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас зохих ёсоор биелүүлээгүй болох нь нотлогдвол үүрэг давагдашгүй хүчин зүйлийг арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Захиалагч төрийн эрх бүхий байгууллагаас хамааралтайгаар гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд саад учирсан тохиолдолд Захиалагчийн үүрэг тухайн нөхцөлийг арилах хүртэл хугацаагаар хойшилно.

Арван долоо. Маргаан шийдвэрлэх

17.1. Талууд харилцан хүндэтгэлтэй, бизнесийн ёс зүйг чанд сахиж, гэрээтэй холбоотой аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.

17.2. Энэхүү гэрээг тайлбарлах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

17.3. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



БАТЛАВ.
МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ЦЭНГЭЛ

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГ ДАХЬ ЗҮҮНБАЯН ӨРТӨӨНӨӨС
 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ ОРШИХ ТАВАНТОЛГОЙ
 НҮҮРСНИЙ ОРД ХҮРТЭЛХ ТӨМӨР ЗАМЫН ШИЛЭН КАБЕЛИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
 БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2019 оны 08 сарын 01-ний өдөр


Улаанбаатар

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<p>Монгол Улсын засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 10 өдрийн 135 дугаар тогтоол</p> <p>"Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг</p> <p>Монгол улсын хүнд үйлдвэр хөгжүүлэх цогцолбор хөтөлбөр</p> <p>Монгол улсын эрчим хүчний салбарын ойрын үйл ажиллагааны хөтөлбөр</p>
2	Байршил	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Эрдэнэс Тавантолгой ХК-ийн уурхайгаас Дорноговь аймгийн Сайншанд суман дахь УБТЗ ХНН-ийн Зүүнбаян өртөө
3	Төлөвлөлтийн норм, стандарт	<ul style="list-style-type: none"> ❖ Харилцаа холбооны тухай хууль; ❖ Байгаль орчныг хамгаалах тухай хууль; ❖ Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм; ❖ Холбооны кабель шугамын ажлын зураг төсөв хийх стандарт MNS 6305 : 2012; ❖ Шилэн кабелийн угсралт, сууриуулалтын стандарт MNS 5278 : 2012; ❖ Холбооны кабелийн суурилуулалт, ерөнхий шаардлага MNS 5276 : 2003; ❖ Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад норм стандарт.
4	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	
5	Захиалагч байгууллага	"Монголын төмөр зам" ТӨХК
6	Зураг төсөл боловсруулах байгууллага	Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний зураг төсөл гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй дотоодын болон гадаадын байгууллага байна.
7	Зураг төслийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> ❖ Дэвсгэр зургийн тодруулалт ❖ Иж бүрэн ажлын зураг ❖ Батлагдсан төсөв ❖ Ажлын тоо хэмжээний жагсаалт ❖ Магадлалын ерөнхий дүгнэлт <p><u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> ❖ Зураг төслийн баримт бичиг З хувь. Электрон файл хэлбэрээр зураг төслийг хүлээлгэн өгөх.

		<ul style="list-style-type: none"> ❖ Ажлын зураг инженерийн бэлтгэл арга хэмжээ, шугам сүлжээний одоогийн байдал болон төлөвлөлтийн дэвсгэр зураг дээр нэгтгэн норм стандартын дагуу төлөвлөж шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай.
8	Зураг төслийн үе шат	Зураг төсөл боловсруулах 1 үе шаттай. Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ.
9	Шилэн кабелийн шугамын эхлэл, төгсгөл	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн уурхайгаас Дорноговь аймгийн Сайншанд сумын УБТЗ ХНН-ийн Зүүнбаян өртөө
10	Технологийн шийдэл	Зураг төсөл боловсруулах хүчин төгөлдөр мөрдөгдж буй норм, дүрмийг баримтлан сүүлийн үеийн дэвшилтээ шийдлүүдийг сонгох
11	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> ❖ Өртөө, зөрлөгийн барилга, байгууламжийг шилэн кабелийн сүлжээнд холбох ❖ 24 шөрмөс бүхий шилэн кабелиар төмөр замын шугамын дагуу өртөө, зөрлөгийн удирлагын байр хооронд үндсэн ба нөөц сүлжээ /цагираг/ үүсгэх ❖ Орон нутагт зохион байгуулагдаж байгаа бусад байгууллагын шилэн кабелиар нөөц холболт хийх хувилбарыг гаргах ❖ Шилэн кабелийн сүлжээг өргөтгөх боломжтой байх ❖ Хэрэглэгдэх эд анги, тоног төхөөрөмж, материал нь Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартчилал, тохирлын үнэлгээний гэрчилгээтэй байна. ❖ Кадастрийн зураглалд шилэн кабелийн сүлжээний залгааны байрлал, суурилуулалт хийсэн газар болон нийт трассын дагуух байрлалыг тодорхойлсон байх

ЗӨВШӨӨРСӨН:

ДЭД ЗАХИРАЛ



R.БАТСҮХ

ХЯНАСАН:

ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НЯМЛХАГВА

БОЛОВСРУУЛСАН:

ХОЛБООНЫ ИНЖЕНЕР



Г.ДӨЛГӨӨН

БАТЛАВ. "Арбэл-Алтай" ХХК-ийн
гүйцэтгэх захирал



Ц.НЯМСҮРЭН

Зураг төсөл боловсруулах ажлын график /үе шатаар/

№	Ажилбарууд:	Нэг сарын хугацаанд ажил гүйцэтгэнэ. /үе шатаар/																															
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	
1	Гэрээ байгуулах	■	■	■																													
2	Хайгуул судалгааны ажил				■	■	■	■	■	■	■	■																					
3	Зураг төсөл боловсруулах суурин ажил							■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■	■								
4	Зураг төсөл зөвшилцөх																						■	■	■	■	■	■	■	■	■	■	

ТАЙЛБАР*: Зураг төсөл баталгаажуулах ажил гүйцэтгэгчээс хамаарахгүйгээр хугацаа авах магадлалтай тул гэрээний хугацаанд зөвшилцөх

График гаргасан: "Арбэл-Алтай" ХХК-ийн менежер

Д.ЭНХТУЯА

Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг дахь "УБТЗ" ХНН-ийн Зүүнбаян өртөөнөөс
Өмнөговь аймгийн Цогцэцийн сумын нутагт орших Тавантолгой нүүрсний орд хүртэл
416 км төмөр замын шилэн кабель татах ажлын зургийн үнийн задаргаа

№	Ажлын нэр	Трассын урт/m/	Жишиг үнэ	Нийт үнэ
1	сувагчлал урт			
2	шилэн кабель	830000	344	285,520,000
3	физик кабель			
4	Трассын дагуу инженерийн шугам сүлжээний тодруулга, хайгуул хийх			16,250,000
5	Нийт дун			301,770,000
8	Төсөв 8%			24,141,600
9	Нийт орго			135,911,600
10	Экспертиз 6%			19,554,696.00
11	Нийт дун			345,460,296
12	НӨАТ 10%			34,546,630
13	Нийт үнэ			380,012,925.60

Зураг төслийн үнийг "Зураг төслийн ажлын жишиг үнэ БД81-16-12" номны 51 -р хуудасны гадна холбооны жишиг үнийн 500м-с дээш 1720 төгрөгөөр тооцож манай компанийн зүгээс 20%-р тооцож үнийн саналыг бодлогоо.

Үнийн задаргаа гаргасан:

"Арбэл-Алтай" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Ц.НЯМСҮРЭН

